



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.04.22 № 01/100 ТМ-СМ/2013/22/789

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН
САЙД С.ОЮУН ТАНАА**

Зөрчлийг арилгуулах тухай

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын төсвийн багцын 2012 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар ЖАЙКА байгууллагын төслөөр “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ-ын барилга байгууламж баригдаж 2012 оны 10 сард ашиглалтанд орсон байна. Тус төвийн 2440 м/кв талбай бүхий 3 давхар 6830.5 сая төгрөгийн өртөгтэй барилга, 1820.8 сая төгрөгийн үнэтэй техник тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, 67.1 сая төгрөгийн хангамжийн материал, нийт 8718.4 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь ТӨХ-ны 2012 оны 44 дүгээр тогтоолын 3.2, 3.3, 3.5 д ззасан “Төрийн өмчийн төлөөлөл санхүүгийн тайлан балансад бүртгүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна, хандив, тусламжийн хөрөнгийг данс бүртгэлдээ тусгаж байх асуудлыг хөрөнгө хүлээн авч буй хуулийн этгээд өөрөө хариуцна, хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй, маргаантай тохиолдолд Төрийн өмчийн хороонд асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 дахь “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмыг үндэслэн АЛБАН ШААРДЛАГА өгч байна.

1. “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”-ийн санхүүгийн тайланд дээрх хөрөнгийг бүртгэх
2. Албан шаардлагын биелэлтийг 2013 оны 6 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т ирүүлнэ үү.

АХЛАХ АУДИТОР



Ц.СУГАРМАА

070223